

**БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ, ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУДЫН  
ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2021 ОНЫ ТАЙЛАН**

Ажлын чиглэл	Хэрэгжүүлсэн арга хэмжээ	Биелэлтийн хувь	Биелэлт дутагдалтай байсан бол түүний шалтгаан
Хүний нөөцийн чиглэлээр	<p>Барилга, хот байгуулалтын яам, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, 21 аймаг, нийслэлийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт нийт <b>944</b> төрийн албан хаагч ажиллаж байгаагаас <b>23</b> Ёс зүйн зөвлөлүүдэд <b>110</b> албан хаагчид ажиллаж байна. Эдгээр төрийн албан хаагчдын ажилласан жил дунджаар <b>12.4</b> байна.</p> <p>Ёс зүйн зөвлөлийн албан хаагчид байгууллагадаа, салбарт ёс зүйн зөв хандлага, хариуцлага, төлөвшлийг сайжруулах, албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс ангид байх, албан үүргээ нэр төртэй биелүүлэх зэрэг чиглэлд манлайлал, нөлөөлөл, соён гэгээрүүлэх зэрэг ажлуудыг хэрэгжүүлж байна.</p> <p>Томилгооны хувьд Барилга, хот байгуулалтын яам, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар сул орон тоо нөхөх, албан хаагчдын цалингийн шатлал тогтоох, ажилласан жилийг тооцон олгохдоо Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчдын тусгай шалгалт зохион байгуулах журам болон бусад хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэсэн.</p> <p>Төрийн албаны зөвлөлийн Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх Салбар зөвлөлийн 2021 онд 10 удаагийн хуралдааныг зохион байгуулж 13 асуудлыг шийдвэрлэн 12 тогтоол гарган хэрэгжилтийг хангуулсан байна. Яам, агентлагт 25 сул орон тоог нөхөхөөр 3 удаагийн сонгон шалгаруулалтыг олон нийтэд нээлттэй зарлаж зохион байгуулсан.</p> <p>2021 онд нийт хүний нөөцийн холбогдолтой 128 тушаал гаргаснаас: Томилсон- 48; Чөлөөлсөн -25; Хүүхэд асрах чөлөө-4; Дурсгалын зүйл олгох-3; Буцалтгүй тусламж-3;</p>	100	

Сахилгын шийтгэл-1;  
Ажилчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр-1;  
Зэрэг дэвийн нэмэгдэл олгох-2;  
Төрийн албан хаасан хугацааны нэмэгдэл олгох-2;  
Цалингийн шатлал ахиулах-1;  
Цалингийн шатлал ахиулах-1;  
Бусад -38 тушаалыг тус тус гаргасан. Тушаалын хэрэгжилт бүрэн хангагдсан.  
Төрийн албаны зөвлөлийн Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх салбар зөвлөлийн шийдвэрээр Барилга, хот байгуулалтын яамны сайдын Б/92, Б/240 дугаар Төрийн захиргааны албан хаагчдын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох тухай тушаалаар яамны 31 албан хаагчдын зэрэг дэвийг нэмэгдүүлсэн. Үүнд:  
Ахлах түшмэлийн тэргүүн зэрэг-2 албан хаагч;  
Ахлах түшмэлийн дэд зэрэг-4 албан хаагч;  
Ахлах түшмэлийн гутгаар зэрэг-2 албан хаагч;  
Ахлах түшмэлийн дөтгөөр зэрэг-7;  
Дэс түшмэлийн гутгаар зэрэг-3 албан хаагч;  
Дэс түшмэлийн дөтгөөр зэрэг -4 албан хаагч байна.  
Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас  
Дэс түшмэл тэргүүн зэрэг-1 албан хаагч  
Дэс түшмэл гутгаар зэрэг-2 албан хаагч  
Дэс түшмэлийн дөтгөөр зэрэг-4 албан хаагчид тус тус зэрэг дэвийн нэмэгдлийг олгуулсан.  
Төрийн нарийн бичгийн даргын Б/54, Б/126 тушаалаар яамны 9 албан хаагчийн төрд ажилласан жилийн нэмэгдлийг шийдвэрлэсэн.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар 2021 онд түр ажиллаж байсан болон мерит зарчмаар дэвшин ажиллаж байгаа, төрийн албаны тусгай шалгалтанд орж байгаа зэрэг хүний нөөцийн чиглэлээр ёс зүйн дүгнэлт 18, геодезийн багаж баталгаажуулалтын лабораторийн үйл ажиллагаатай холбоотой дүгнэлт 1, бүгд 19 дүгнэлт гаргасан байна.

Орон нутаг дахь харьяа байгууллагуудын хүний нөөцийн мэдээллийг холбогдох байгууллагуудад мэдээлж ажиллаа. Тухайлбал:

**Архангай:** 2021 онд үндсэн 39, захиалагчийн 6 нийт 45 орон тоотой үйл ажиллагаа явуулсан. Өнөөдрийн байдлаар жирэмсний амралттай 4, удаан хугацаагаар өвчний чөлөөтэй 1 нийт 5 орон тоо түр чөлөөлөгдсөн бөгөөд тухай бүр түр орлон гүйцэтгэгчийг томилж ажилласан. Мөн 2021 онд төрийн албаны ерөнхий шалгалтад 6 албан хаагчийн хамруулснаас 4 албан хаагч тэнцсэн. Төрийн албаны зөвлөлийн Архангай аймаг дахь салбар зөвлөлд тусгай шалгалтын 6 захиалга хүргүүлж тусгай шалгалтад тэнцсэн 4 албан хаагчийг жинхлэн томилж, тусгай шалгалт зарлагдсан ч шалгалтад хүн ороогүй 2 орон тоонд өмнө ажиллаж байсан 2 албан хаагчийн буцаан төрийн албаны ерөнхий болон тусгай шалгалтад тэнцэх болзол нөхцөлтэйгөөр түр орлон гүйцэтгэгчээр томилж ажилласан. 2022 онд тусгай шалгалт зарлагдаагүй байгаа 2 орон тоонд тусгай шалгалт зарлуулан албан хаагчдыг жинхэлэн томилуулахаар ажиллаж байна.

**Булган аймгийн** Сэлэнгэ сумын ЗДТГ-аас газрын даамлын үйл ажиллагаатай холбоотой гомдол мэдээлэл ирсний дагуу Булган сумын газрын даамал У.С-д сануулах арга хэмжээ, Сэлэнгэ сумын газрын даамал Г.М-ын 6 сарын цалинг 20 хувиар бууруулах арга хэмжээг тус тус авсан байна.

**Говь-Сүмбэр:** Сул орон тоог ажлын байрны тодорхойлолтын дагуу аймгийн Төрийн албаны салбар зөвлөлд 2 удаа хүргүүлэн ажилласан. Шинээр 2021 онд ажилд орсон 3 төрийн албан хаагчийг байгууллагын дотоод журам, Төрийн жинхэнэ болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэмтэй 2021 оны 7 дугаар сард танилцуулан гарын үсэг зуруулан баталгаажуулсан.

**Дорноговь:**

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор "Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм", баталсантай холбогдуулан Газрын даргын 2019 оны А/15 дугаар тушаалаар Байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн баталж, хэрэгжилтийг ханган ажилласан.

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын шуурхай зөвлөгөөн зохион байгуулах журмыг тус газрын 2021 оны А/101 дүгээр тушаалаар баталсан ба уг журамд зөвлөгөөний бүрэлдэхүүн, дэгийг тогтоосон. Тайлант онд байгууллагын шуурхай зөвлөгөөнийг 3 удаа хуралдуулж, хэрэгжилтийг ханган ажилласан.

**Дорнод:** Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2019 оны А/123 дугаар тушаалаар тус байгууллагыг 34 орон тоотой баталсан боловч аймгийн Ерөнхий архитектор нь аймгийн Засаг даргын захирамжаар томилогдон нийт 35 орон тоотой ажиллаж байна. 2021 оны жилийн эцсийн байдлаар 31 орон тоотой ажилласан.

Ерөнхий архитекторыг шилжүүлэх талаар хүсэлтээ аймгийн Засаг даргад уламжлаад байна.

**Дундговь:** 2021 онд тус байгууллагад 6 албан хаагч шинээр томилогдсон. Шинээр томилогдохоор дэвшүүлсэн албан хаагчдын ажлын түүх, харилцаа хандлага, ёс зүйтэй холбоотой ярилцлагыг зохион байгуулсан.

**Завхан:** ГХБХБГ-ын төрийн захиргааны болон үйлчилгээний 43 ажилтан алба хаагчдын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд Төрийн албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлэн ажиллах заалтыг тусган хагас бүтэн жилээр дүгнэн ажилласан.

**Сүхбаатар:** Зөрчил гаргасан Халзан сумын газрын даамал М.Э-ийн алдаа дутагдлыг хэлэлцэн "Төрийн албаны тухай" хуулийн дагуу гаргасан зөрчил дутагдалд нь тохирсон шийтгэл оногдуулах нь зүйтэй гэж үзэн байгууллагын Дээд шатны албан тушаалтан болон "Газрын даргын дэргэдэх зөвлөл"-д шилжүүлсэн ба тус зөвлөл нь эхний зөрчилд сахилгын арга хэмжээ, дараагийн зөрчилд ажлаас чөлөөлөх арга хэмжээ тус тус авч ажилласан.

**Сэлэнгэ:** 2021 оны жилийн эцсийн байдлаар удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэхдээ хугацаа хоцроосон, үүрэгт ажилдаа хариуцлагагүй хандсан тул Төрийн албаны тухай хуулийн 48 дүгээр зүйлийн 48.1, 48.3, "Төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах, түүнд гомдол гаргах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.6, "Байгууллагын дотоод журам"-ын 9 дүгээр зүйлийн 9.7 дахь заалтыг тус тус үндэслэн 1 албан хаагчид 1 сарын цалинг 20%-аар бууруулах, мөн 1 албан хаагчид сануулах сахилгын шийтгэл ногдуулж хариуцлага тооцов.

**Төв:** Төрийн албаны зөвлөлийн Төв аймаг дахь салбар зөвлөлийн 2021 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 07 тоот албан бичгээр ирүүлсэн захиалгын дагуу Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2, 27.1.3 дахь заалт, "Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам"-ын 2.1, 2.3-т заасныг үндэслэн Төв аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Алтанбулаг, Баянжаргалан, Дэлгэрхаан, Өндөрширээт, Сэргэлэн сумын Газрын даамал /5/ албан тушаалын сонгон шалгаруулалтын зарыг олон нийтэд зарлаж 2021 оны 05, 07 дугаар тогтоолоор төрийн жинхэнэ албан тушаалд тавигдах нийтлэг болон тусгай шаардлагыг хангасан Ч.Мөнхгэрэлийг Алтанбулаг сумын газрын даамлаар, Б.Халиунааг Сэргэлэн сумын газрын даамлаар, Р.Заяадэлгэрийг Дэлгэрхаан сумын газрын даамлаар тус тус томилсон. Төрийн албаны зөвлөлийн Төв аймаг дахь салбар зөвлөлөөс 2021.12.06-ны өдөр зохион байгуулсан тусгай шалгалтын дүнг үндэслэн Инженерийн дэд бүтцийн асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд Б.Давааням, Хот байгуулалтын

Төв аймгийн Баянжаргалан, Бүрэн, Өндөрширээт сумд нь алслагдмал сум учраас төрийн албаны шалгалтад орох иргэн олдохгүй, иргэд төрийн албаны шалгалтад тэнцэхгүй байгаа нь сул ажлын байр нөхөгдөх боломж сул байна.

	<p>кадастр, зураг төсөл, магадлал хариуцсан мэргэжилтний албан тушаалд Б.Бат-Оргил, Баян-Өнжүүл сумын газрын даамлын албан тушаалд М.Хандсүрэнг томилон ажиллуулж байна. 2021 оны 12 сарын 08-ны өдрийн байдлаар Өндөрширээт, Баянжаргалан, Баянцагаан, Бүрэн сумдын газрын даамлын орон тоо сул байгаа бөгөөд Төрийн албаны зөвлөлийн Төв аймаг дахь салбар зөвлөлд орон тоог нөхүүлэх тухай саналаа албан тоотоор хүргүүлээд байна.</p>		
<p>Гомдол мэдээллийн ёс зүйн зөрчлийн судалгаа, тайлан, дүн шинжилгээний чиглэлээр</p>	<p>БХБЯ, агентлаг, харьяа байгууллагууд төрийн албан хаагч, иргэнээс ирүүлсэн гомдлыг тухай бүр хянан үзээд шийдвэрлэж ажилласан мэдээллийг хагас, бүтэн жилээр гарган ТАЗ-д хүргүүлсэн. Тухайлбал: Архангай аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт иргэнээс ирүүлсэн гомдлын дагуу байгууллагын Ёс зүйн зөвлөл хяналт, шалгалтыг 2021 оны 06 дугаар сарын 20-25-ны хугацаанд хийж тухайн хяналт шалгалтын дүгнэлтийг үндэслэн Цэнхэр сумын газрын даамал Т.М-д газрын даргын 2021 оны 06 дугаар сарын 29-ний Б/38 дугаартай тушаалын дагуу 1 сарын хугацаанд 20 хувиар цалин бууруулах сахилгын шийтгэл ногдуулсан байна.</p> <p>Ёс зүйн зөрчлийг тухай бүр шийдвэрлэж, холбогдох арга хэмжээ авч, зөв хандлага, хариуцлага, төлөвшлөөр манлайлах, нөлөөлөх, соён гэгээрүүлэх ажлуудыг хэрэгжүүлснээр албан хаагчдыг ёс зүйн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, Засгийн газрын 2019 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 33 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг хэрэгжүүлэхэд үр дүнтэй нөлөө үзүүлсэн.</p> <p><b>Булган:</b> Төрийн албан хаагчийн ёс зүй, төрийн байгууллагын соёл, дэг журмыг чанд сахиж, мэргэжил мэдлэгээ байнга дээшлүүлж, мэргэжлийн өндөр ур чадвар, идэвхи санаачилга гарган албан үүргээ тогтмол чанартай биелүүлж, ажлын өндөр амжилт үзүүлсэн албан хаагчийг шагнаж урамшуулж байхаар байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 8.1-т тусгайлан зааж өгсөн.</p> <p><b>Говьсүмбэр:</b> Байгууллагын албан хаагчийн үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тохиолдолд дүн шинжилгээ хийх, хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий орон тооны бус “Ёс зүйн зөвлөлийн ажиллах журам”-ыг байгууллагын даргын 2021 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн А/17 дугаар тушаалаар батлуулсан.</p> <p><b>Дорноговь:</b> 2021 онд нийт албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой 1 гомдол ирсэн. Гомдлын дагуу албан хаагчийг ёс зүйн зөвлөлийн хурлаар оруулж асуудлыг судалж, холбогдох арга хэмжээг авсан.</p>	<p>100</p>	<p>-</p>

**Дорнод:** Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолын дагуу байгууллагын даргын 2021 оны А/22 дугаар тушаалаар ёс зүйн зөвлөл болон зөвлөлийн ажиллах журмыг батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Тайлант онд байгууллагын Ёс зүйн зөвлөл 2 удаа хуралдсан. Засгийн газрын 11-11 төвөөр дамжин албан хаагчийн ёс зүйтэй холбоотой 1 иргэнээс гомдол ирснийг хүлээн авч судлахад хариуцлага хүлээлгэх үндэслэл тогтоогдоогүй тул хариуг 2021-02-09-ны өдрийн 1/107 тоот албан бичгээр хүргүүлсэн.

**Дундговь:** Сүүлийн 3 жилийн хугацаанд байгууллагын албан хаагчийн ёс зүйтэй холбоотой гомдол ирээгүй. Байгууллагын албан хаагчдын ёс зүйн зөрчил гаргасан бүртгэлийг хөтлөн ажилласан.

**Завхан:** Ёс зүйн зөвлөлд ирүүлсэн өргөдөл гомдлын мөрөөр хуралдаан зохион байгуулж 1 өргөдлийг Дотоод хяналт руу шилжүүлж, 1 өргөдлийн гомдол гаргагч өргөдлөө буцаан татсан тул хариу хүргүүлж, 1 өргөдөл ёс зүйн хэм хэмжээ алдсан гэж гэж үзэж сануулах арга хэмжээ авсан.

**Өвөрхангай:** Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлэн хугацаатай мэдээ, судалгааг удаа дараалан хоцроосон 2 албан хаагчид үндсэн цалингийн 20 хувиар бууруулан олгох арга хэмжээг авахаар ёс зүйн хороогоор шийдвэрлэн албан хаагчидтай сонсох ажиллагаа явуулан газрын даргын тушаалаар хэрэгжүүллээ.

**Өмнөговь:** Төрийн албан хаагчийн ёс зүй, төрийн байгууллагын соёл, дэг журмыг чанд сахиж, мэргэжил мэдлэгээ байнга дээшлүүлж, мэргэжлийн өндөр ур чадвар, идэвх санаачилга гарган албан үүргээ тогтмол чанартай биелүүлж, ажлын өндөр амжилт үзүүлсэн албан хаагчийг шагнаж урамшуулж байхаар байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 8.1-т тусгайлан зааж өгсөн.

**Увс:** Албан хаагчдаас хамтран ажиллаж буй албан хаагчдын ёс зүйтэй холбоотой гомдол байгаа эсэх талаар ярилцаж судалхад ёс зүйн зөрчил, гомдол байхгүй байна.

**Ховд:** Албан хаагчдын харилцаа хандлагыг дээшлүүлэх талаар: Албан хаагчдын харилцаа хандлага ямар түвшинд байгааг тодорхойлох зорилгоор Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2020 оны А/219 дүгээр тушаалаар батлагдсан асуулгын дагуу хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн судалгааг 2021 оны 12 дугаар сарын 01-31-ны өдрүүдэд авч ажиллаа. Судалгааны дүнг 2022 оны 01 дүгээр сард нэгтгэж анхаарч ажиллах талаар зөвлөмжийг албан хаагч бүрт өгсөн.

<p>Ёс зүйн зөрчлүүдийн шийдвэрлэлтийн үр дүн</p>	<p>Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх Төрийн албан хаагчийн 2021 онд албан хаагчдын ёс зүйн зөрчил бүртгэгдээгүй бөгөөд энэ талаар гомдол, мэдээлэл ирээгүй болно.</p> <p>Ёс зүйн зөрчлийг тухай бүр шийдвэрлэж, арга хэмжээ авах нь бусад албан хаагчид ёс зүйн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх чухал нөлөөтэй байна.</p> <p>Булган сум, Сэлэнгэ сумын ЗДТГ-аас газрын даамлын үйл ажиллагаатай холбоотой гомдол мэдээлэл ирсний дагуу арга хэмжээ авч ажилласан. Өөр албан хаагч ёс зүйн зөрчил гаргасан талаар гомдол мэдээ ирээгүй болно.</p> <p><b>Говь-Алтай:</b> Төрийн албаны тухай хууль болон байгууллагын дотоод журам зөрчин Ажлын цагаар болон ажлын байранд, томилолтоор ажиллах, ажил үүргээ гүйцэтгэж байх үедээ архи, согтууруулах ундааны зүйл, мансууруулах бодис хэрэглэсэн түүнийг зохион байгуулсан, ажилдаа согтуурсан буюу мансуурсан Ж.М, Н.Г, Г.Б нарыг ёс зүйн хорооны 2021.01.27-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн 2021.01.28-ны өдрийн А/03, А/04, А/05 дугаар тушаалуудаар сануулах арга хэмжээг тус тус авсан.</p> <p><b>Говьсүмбэр:</b> Ёс зүйтэй холбоотой 1 гомдол ирснийг судлаад Авилгатай тэмцэх газарт давхардуулан өгсөн тул байгууллагын “Ёс зүйн зөвлөлийн ажиллах журам”-ын 4.3-д заасны дагуу буцаасан болно.</p> <p><b>Дорноговь:</b> Нэг /1/ албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой ирсэн 1 гомдолд нөгөө талын ашиг сонирхлын зөрчил байгааг харгалзан сануулах арга хэмжээ авсан.</p> <p><b>Дорнод:</b> Тайлант хугацаанд албан хаагчдын ёс зүйтэй холбоотой 1 гомдол ирсэн. Гомдлын дагуу Газрын даргын 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/02 дугаар тушаалаар ажлын хэсэг томилогдон ажиллаж судлахад хариуцлага хүлээлгэх үндэслэл тогтоогдоогүй тул хариуг 2021-02-09-ны өдрийн 1/107 тоот албан бичгээр хүргүүлсэн.</p> <p><b>Дундговь:</b> 2021 оны 4 дүгээр сард ажлын цагаар архи хэрэглэсэн 2 албан хаагчид сонсох ажиллагаа явуулж, сануулсан.</p> <p><b>Завхан:</b> Ёс зүйн зөвлөлд ирүүлсэн өргөдөл гомдлын мөрөөр хуралдаан зохион байгуулж 1 өргөдлийг Дотоод хяналт руу шилжүүлж, 1 өргөдлийн гомдол гаргагч өргөдлөө буцаан татсан тул хариу хүргүүлж, 1 өргөдөл ёс зүйн хэм хэмжээ алдсан гэж үзэж сануулах арга хэмжээ авсан.</p> <p><b>Ховд:</b> Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг шинээр томилогдсон 4 албан хаагчдад танилцуулж, албан хаагчдын өрөө тус бүрт ёс зүйн дүрмийг самбарт байршуулан, дагаж мөрдөж ажиллахыг сурталчлав. Мөн зөвлөлийн гишүүнийг 2021 оны 11 дүгээр сарын 11-12 ны өдрүүдэд ТАЗ, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Монгол</p>	<p>100</p>	<p>-</p>
--	--	------------	----------

	<p>улсад мэргэжийн иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь төслөөс зохион байгуулсан "Цогц чадамжид суурилсан хүний нөөцийн удирдлага, Төрийн байгууллагын дэргэдэх ёс зүйн зөвлөлийг чадавхижуулах бүсийн сургалт"-д хамруулсан. Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн эсэх талаар 7 албан хаагчийн асуудлыг хэлэлцэж, ёс зүйн хариуцлага хүлээлгэхгүйгээр шийдвэрлэсэн.</p> <p><b>Хэнтий:</b> Иргэний гомдлын дагуу Галшар сумын Газрын даамалд ёс зүйн хариуцлага хүлээлгэсэн.</p>		
<p>Сургалт, соён гэгээрэл, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны чиглэлээр</p>	<p>Төрийн албаны зөвлөлөөс 2021 оны 8 дугаар сарын 27-нд зохион байгуулсан “Ёс зүйн зөвлөлийг чадавхижуулах сургалт”-д албан хаагчдыг хамруулан, оролцсон. Мөн Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан 3 өдрийн сургалтад Ёс зүйн зөвлөлийн дарга, гишүүд бүрэн хамрагдсан.</p> <p>Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисс 2021 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр “Төрийн захиргааны албан хаагчдын ажлын байрны бэлгийн дарамтын мэдлэг, хандлага, зан үйлийн судалгаа”-ны үр дүнг танилцуулах цахим хэвлэлийн хуралд оролцсон. Ажлын байрны бэлгийн дарамт /АББД/-ыг таслан зогсоох чиглэлээр явуулж буй соён гэрээрүүлэх сургалт, сурталчилгааны материалуудыг яам, харьяа байгууллагуудын цахим сүлжээгээр албан хаагчдад түгээсэн.</p> <p>Танилцуулгад АББД гэж юу болох, үүнтэй холбоотой гомдол, мэдээллийг хаана хандах, төрийн албан хаагч энэ талаар гэм буруутай нь нотлогдсон тохиолдолд түүнд ямар хариуцлага хүлээлгэх болон бусад мэдээлэл багтаасан. Хүн бүр төрийн албан хаагчийн болон хувь хүний баримтлах зарчим, ёс зүйн хэм хэмжээг амьдрал, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх эрхэм үүрэгтэй, өөрийн эрхээ хамгаалах, хамгаалуулах эрхтэй болохыг мөн мэдэгдсэн.</p> <p>БХБЯ-ны дэргэдэх Төрийн албан хаагчийн ёс зүйн зөвлөл “Төрийн албан хаагчийн Ёс зүй” сэдэвт сургалтыг цахимаар 10 дугаар сарын 19-ны өдөр зохион байгуулж, харьяа байгууллагууд, аймгийн ГХБХБГ-уудаас <b>100</b> ажилтнууд оролцсон.</p> <p>Хорин нэгэн /21/ аймагт үйл ажиллагаа явуулж буй Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газруудад чиглэл өгч ажилласны үр дүнд танхим, цахимаар нийт тоогоор 42 удаагийн сургалт, соён гэгээрүүлэх ажил зохион байгуулагдсан. Тухайлбал:</p>	<p>100</p>	<p>-</p>



**Архангай** аймагт байгууллагын нийт албан хаагчдыг чадавхижуулах, хууль эрх зүйн мэдлэг олгох, Төрийн албаны болон 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс шинээр мөрдөгдөх Хөдөлмөрийн тухай хуулийг таниулах хүрээнд 2 удаагийн сургалтыг 2021 оны 06 болон 10 дугаар сард цахимаар зохион байгуулсан. Мөн 2022 оны 10 дугаар сард “Чингис хааны ёс суртахуун” нэртэй танин мэдэхүйн сургалтыг цахимаар зохион байгуулж нийт албан хаагчдыг хамруулж ажилласан. Төрийн албаны тухай хуульд заагдсан төрийн албан хаагчийн ёс зүйтэй холбоотой хэсгийг нийт албан хаагчдад танилцуулж, Хөдөлмөрийн гэрээнд ёс зүйн зөрчлийн шийдвэрлэлтийг тодорхой тусгасан. Мөн Хөдөлмөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжсэнтэй холбогдуулан байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг шинэчлэн, журамд ёс зүйн зөрчил, түүнд ногдуулах хариуцлага, сургалт сурталчилгааны ажлыг тодорхой тусгахаар ажиллаж байна.

**Говьсүмбэр:** Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын ёс зүйн зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 2021.3.30-ны өдөр батлуулсан. Төлөвлөгөөнд тусгагдсан 11 арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажилласан. Ёс зүйн зөвлөлөөс 2021 онд танхимын сургалтыг 1, цахим сургалтыг 2 удаа зохион байгууллаа.

**Дорноговь:** ГЗБГЗЗГазрын даргын 2021 оны А/25 тушаал, аймгийн Засаг даргын 2021 оны А/47 тоот захирамжаар батлагдсан газрын харилцааны салбар болон аймгийн хэмжээнд авлигын эсрэг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэслэн тус газрын 2021 оны Авлигатай тэмцэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан газрын даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан. Уг төлөвлөгөөний дагуу байгууллагын албан хаагчдад 2021.03.22-ны өдөр 1 удаагийн цахим сургалтаар авлигаас урьдчилан сэргийлэх талаар мэдээллийг өгч, байгууллагын дотоод сүлжээ АВЛЕ систем, мэдээллийн самбарт гарын авлага материалыг байршуулан сурталчлан ажилласан. 11 дүгээр сарын 22-ны өдөр Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас зохион байгуулсан “Авлигын эсрэг” цахим сургалтанд 2 албан хаагч хамрагдсан.

**Дорнод:** Авлигатай тэмцэх газраас аймгийн хэмжээнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулж буй “ЗӨВ ЗӨВД ШУДАРГА ЗӨВ” аяны хүрээнд зохион байгуулсан “Хууль сурталчлах” өдөрлөгт 4 албан хаагч оролцож газрын харилцааны цахим шилжилттэй холбоотой мэдээ мэдээлэл, заавар зөвлөгөөг өгч ажилласан.

АТГ-аас цахим хэлбэрээр зохион байгуулсан сургалтуудад байгууллагын эрх бүхий албан тушаалтан тогтмол хамрагдсан. Газрын харилцааны салбарын албан хаагчдад зориулсан “Авлигын эсрэг” цахим сургалтад 19 албан хаагч хамруулсан.

Тайлант хугацаанд “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдвээр 2 удаа сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 22 албан хаагчийг хамруулсан. Үүнд шинээр томилогдсон 4 албан хаагч болон сумдын газрын даамлуудад Төрийн албаны тухай хууль болон түүнтэй холбогдон гарсан заавар журам, Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийн талаар сургалт хийж мэдээлэл өгсөн.

**Дундговь:** Байгууллагын албан хаагчдад 2021.05.06-ны өдөр, 2021.11.04-ний өдрийн “Хуулийн цаг” арга хэмжээгээр Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, түүнийг ажиллах үедээ мөрдөн ажиллах тухай сургалт танилцуулгыг бэлтгэн хүргэсэн. 2 удаагийн сургалтаар давхардсан тоогоор 13 албан хаагч хамрагдсан байна.

2021 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр Авилга, төрийн албан хаагчийн ёс зүй сэдэвт хөгжөөнт “ТА ТА ТУНГАА” тэмцээнийг зохион байгуулсан ба нийт 12 албан хаагч оролцсон.

**Завхан:** 2021 оны 10 сарын 12-ны өдөр “ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН ЁС ЗҮЙ” сэдвээр ГХБХБГ-ын ажилтан алба хаагчдад сургалт зохион байгуулсан.

**Өвөрхангай:** Аймгийн Засаг даргын “Төрийн албан хаагчдын сахилга хариуцлагыг дээшлүүлэх тухай” захирамжийг байгууллагын 19 албан хаагчид танилцуулан 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг хангуулж ажиллалаа.

**Өмнөговь:** 2021 оны 10 сарын 18-ны өдөр Өвөрхангай аймагт болсон “Ёс зүй цогц чадамж буюу хүний нөөцийн удирдлага” сургалтад байгууллагын ёс зүйн зөвлөлийн гишүүнийг хамруулсан.

**Сүхбаатар:** Шинээр томилогдсон болон бусад албан хаагчдад Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолын хавсралт болох “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг танилцуулах сургалт зохион байгуулсан.

**Сэлэнгэ:** Хүн Төвтэй Байгаль Хамгаалал байгууллагаас хэрэгжүүлж буй “Газар Эдэлбэрийн Баталгаат Байдал” төслийн хүрээнд зохион байгуулагдаж байгаа “Сумын Нутаг Дэвсгэрийн Хөгжлийн Төлөвлөгөө Боловсруулах явцад Олон Нийттэй Зөвлөлдөх Гарын Авлага”-ын танилцуулах болон иргэдээс санал авах ажил зохион байгуулахад албан хаагчийн харилцаа, хандлага, биеийн хэлэмжийг илэрхийлэх чадамжийг хэрхэн төлөвшүүлэх талаарх цахим сургалтанд 17 сумын газрын даамлуудыг хамруулав.

**Төв:** Төрийн албан хаагчийн сургалтын төлөвлөгөөг боловсруулан Газрын даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан. Газрын харилцааны салбарын 2021 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт /жилийн эцсийн байдлаар/ Газрын харилцааны салбарын авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 2 дахь үе шатыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт /жилийн эцсийн байдлаар/ нийт 58 зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг гаргаж ГХБХБГазрын 2021 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 07/920 тоот албан бичгээр ГЗБГЗЗГазарт хүргүүлсэн.

**Увс:** Байгууллагын Ёс зүйн хороог шинчлэн байгуулах тухай 2021 оны А/14 дүгээр тушаал, Ёс зүйн дүрмийг нийт албан хаагчдад танилцуулан, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, шаардлага, хүлээх хариуцлагын талаар мэдээлэл өгсөн.

**Ховд:** Албан хаагчдын стрессийн түвшинг бууруулах улмаар ёс зүйн зөрчлийг бууруулах зорилгоор сэтгэл ханамжийн 7 хэсэг, 51 асуулга бүхий судалгааг 2021 оны 11 дүгээр сарын 10-17-ны өдрүүдэд авч нэгтгэн, албан хаагчдад зөвлөмж өгч ажиллаа. Мөн биеийн тамирын спортын газартай гэрээ байгуулан долоо хоног бүрийн Лхагва гаригт тогтмол зааланд тоглож байна.

**Хэнтий:** 2021 оны 12 дугаар сард зохион байгуулсан Газрын даамлын сургалтаар Ёс зүйн хэм хэмжээний талаар холбогдох сургалтыг зохион байгуулсан. Мөн тус аймагт зохион байгуулагдсан Ёс зүйн зөвлөлийн зүүн бусийн сургалтад хамрагдсан.

-----\*\*\*-----